

**БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2017-2018 ОНЫ
ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Бага, дунд боловсролын сургалтын байгууллага (байршил, өмчийн хэлбэр, ангилал)

2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын 798 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Тэдгээрийн 81.7 хувь нь төрийн өмчийн, 18.3 хувь нь хувийн сургууль байна. (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Ерөнхий боловсролын сургуулийн тоо (өмчийн хэлбэр, ангилалаар)

	Ерөнхий боловсролын сургууль							
	Бүгд	төрийн	хувийн	Бүгд	бага	дунд	ахлах	цогцолбор
2013-2014	756	628	128	756	61	130	522	43
2014-2015	762	628	134	762	62	136	514	50
2015-2016	768	636	132	768	62	118	538	50
2016-2017	778	645	133	778	69	117	542	50
2017-2018	798	652	146	798	74	116	562	46

2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар нийт сургуулийн 74 буюу 9.3 хувь нь бага сургууль, 116 буюу 14.5 хувь нь дунд сургууль, 562 буюу 70.4 хувь нь ахлах сургууль, 46 буюу 5.8 хувь нь цогцолбор сургуулийн ангилалд багтаж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад бага сургуулийн тоо 5-аар, ахлах сургуулийн тоо 20-оор өссөн бол, дунд сургуулийн тоо 1-ээр, цогцолбор сургуулийн тоо 4-өөр тус тус буурсан байна.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 56 (8.6%) нь бага сургуулийн, 115 (17.6%) нь дунд сургуулийн, 440 (67.5%) нь ахлах сургууль, 41 (6.3%) нь цогцолбор сургуулийн; Хувийн сургуулийн 18 (12.3%) нь бага сургуулийн, 1 (0.7) нь дунд сургуулийн, 122 (83.6%) нь ахлах сургуулийн, 5 (3.4%) нь цогцолбор сургуулийн ангилалд тус тус багтаж сургалтын ажил эрхэлж байна.

Хүснэгт 2. Ерөнхий боловсролын сургууль (байршил, хэв шинжээр)

	Ерөнхий боловсролын сургууль								
	Бүгд	хот	хөдөө	Бүгд	ердийн	мэргэ жлийн	гүнзгий рүүлсэн	тусгай	олон улсын хөтөлбөр
2013-2014	756	208	548	756	706	11	33	6	-
2014-2015	762	214	548	762	633	14	100	6	9
2015-2016	768	215	553	768	662	14	81	6	5
2016-2017	778	226	552	778	684	15	66	6	7
2017-2018	798	241	557	798	705	16	63	6	8

Нийт сургуулийн 69.8 хувь буюу 557 нь хөдөөд, 30.2 хувь буюу 241 нь нийслэлд сургалтын ажил эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 705 буюу 88.3 хувь нь ердийн, 16 буюу 2.0 хувь нь мэргэжлийн, 63 буюу 7.9 хувь нь гүнзгийрүүлсэн, 6 буюу 0.8 хувь нь тусгай, 8 буюу 1.0 хувь нь олон улсын хөтөлбөрөөр сургалт явуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг, бүлэг дүүргэлт (өдрийн анги)

Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 20.2 мянган бүлэг хичээллэж байна. Нийт бүлгийн 18.2 мянга буюу 90.3 хувь нь төрийн өмчийн, 2.0 мянга буюу 9.7 хувь нь хувийн сургуульд ногдож байгаа бөгөөд нийт бүлгийн 50.5 хувийг *бага*, 32.4 хувийг *дунд*, 17.0 хувийг *ахлах ангийн* бүлэг тус тус бүрдүүлж байна. Бүлгийн тоо өнгөрсөн хичээлийн жилээс 2.6 хувь (үүнээс бага анги 4.3, дунд анги 6.2 хувиар өссөн бол, ахлах анги 7.8 хувиар буурсан)-иар өссөн (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг (өдрийн анги, ээлж, тоогоор)

	Бүлгийн тоо							
	Бүгд	Бага	Дунд	Ахлах	Бүгд	1-р ээлж	2-р ээлж	3-р ээлж
2013-2014	17,960	8,774	5,767	3,419	17,960	11,323	6,496	141
2014-2015	18,521	9,132	5,739	3,650	18,521	11,734	6,630	157
2015-2016	19,304	9,554	5,429	4,321	19,304	12,058	7,071	175
2016-2017	19,677	9,795	6,171	3,711	19,677	12,215	7,238	224
2017-2018	20,211	10,214	6,553	3,444	20,211	12,705	7,320	186

Ерөнхий боловсролын сургуулийн нийт бүлгийн 62.9 хувь нь нэгдүгээр ээлжинд, 36.2 хувь нь хоёрдугаар ээлжинд, 0.9 хувь нь гуравдугаар ээлжинд хичээллэж байна.

Хүснэгт 4. Ерөнхий боловсролын сургуулийн 3-р ээлжинд хичээллэж байгаа бүлэг, хүүхэд (өдрийн анги, тоогоор)

	Бүлгийн тоо				Хүүхдийн тоо			
	Бүгд	Бага	Дунд	Ахлах	Бүгд	Бага	Дунд	Ахлах
2013-2014	141	128	13	-	4,729	4,213	516	-
2014-2015	157	157	-	-	5,469	5,469	-	-
2015-2016	175	175	-	-	6,311	6,311	-	-
2016-2017	224	218	6	-	8,755	8,566	189	-
2017-2018	186	159	27	-	7,335	6,412	923	-

Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд 25 сургуулийн 186 бүлэгт 7,335 суралцагч 3 ээлжээр хичээллэж байгаа байна. Эдгээр 3-р ээлжийн бүлгийн 85.5 хувь нь бага ангийн, 4.5 хувь нь дунд ангийн бүлэг байна.

Хүснэгт 5. Ерөнхий боловсролын сургуулийн 3-р ээлжинд хичээллэж байгаа бүлэг, хүүхэд (өдрийн анги, тоогоор)

Он		2013-2014 он			2014-2015 он			2015-2016 он			2016-2017 он			2017-2018 он		
Үзүүлэлт	Бүгд	Байршил		Бүгд	Байршил		Бүгд	Байршил		Бүгд	Байршил		Бүгд	Байршил		
		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө	
Сургуулийн тоо		23	22	1	22	21	1	24	23	1	32	31	1	25	22	3
III ээлж	Бүлэг	141	140	1	157	151	6	175	174	1	224	222	2	186	173	13
	Суралцагч	4729	4712	17	5469	5263	206	6311	6278	33	8755	8706	49	7335	6932	403

3 ээлжээр хичээллэж байгаа 25 сургуулийн 3 нь хөдөө аймагт, 22 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Улсын хэмжээнд бүлэг дүүргэлт 28.3 байгаа нь өмнөх жилээс 0.2 пунктээр, үүнээс төрийн өмчийн сургуульд 29.5 байгаа нь өмнөх жилээс 0.5 пунктээр тус тус өссөн бол, хувийн сургуульд 17.8 байгаа нь өмнөх жилээс 0.4 пунктээр буурсан байна.

Бүлэг дүүргэлт нормативт хэмжээнээс дээгүүр буюу 37.0-53.7-той нэр бүхий нийслэлийн 35, аймгийн 5 сургууль:

1. Чингэлтэй дүүрэг: 23-р сургууль (53.7), 5-р сургууль (46.3), 24-р сургууль (42.3), 50-р сургууль (38.4), 139-р сургууль (37.8)

2. Сүхбаатар дүүрэг: 1-р сургууль (50.7), 3-р сургууль (45.0), 31-р сургууль (41.6), 2-р сургууль (39.6), 6-р сургууль (38.5), 45-р сургууль (37.9), 11-р сургууль (37.9), 58-р сургууль (37.4),
3. Хан-уул дүүрэг: 18-р сургууль (50.3), 52-р сургууль (46.4), Буянт-ухаа цогцолбор сургууль (41.5) 118-р сургууль (37.2),
4. Баянзүрх дүүрэг: 84-р сургууль (46.3), 33-р сургууль (43.5), 21-р сургууль (40.9), 44-р сургууль (40.3), 111-р сургууль (39.7), 14-р сургууль (37.7), 97-р сургууль (37.4), 48-р сургууль (37.0),
5. Баянгол дүүрэг: Эрдмийн өргөө цогцолбор сургууль (42.4), 20-р сургууль (42.4), 93-р сургууль (41.8), Оюуны-ундраа цогцолбор сургууль (37.7),
6. Сонгинохайрхан дүүрэг: 12-р сургууль (41.9), 104-р сургууль (39.6), 122-р сургууль (39.1), 62-р сургууль (39.0), Ирээдүй цогцолбор сургууль (38.7), 42-р сургууль (37.0),
7. Баянхонгор аймаг: Баян-ойт бага сургууль (40.6),
8. Дархан-уул аймаг: Оюуны ирээдүй цогцолбор (38.4),
9. Орхон аймаг: 5-р сургууль (38.3), 14-р сургууль (37.7)
10. Хөвсгөл аймаг: Эрдмийн далай цогцолбор сургууль (38.2) байна. Энэ нь өмнөх жилээс 6 сургуулиар нэмэгдсэн байна. Энэ нь хотод 5 сургууль, аймагт 1 сургууль өмнөх жилээр нэмэгдсэн байна.

Суралцагчид

2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 581.2 мянган (өдрөөр 572,752, оройгоор 111, эчнээгээр 350, дүйцсэн хөтөлбөрөөр 7,947) суралцагч өдөр, орой, эчнээ, дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж байна. Насан туршийн боловсролын төвд 7,947 хүүхэд дүйцсэн хэлбэрээр суралцаж байна. Суралцагчдын тоо өнгөрсөн хичээлийн жилээс 19,467-оор, үүнээс өдрөөр суралцагч 20,799-өөр тус тус өссөн бол, эчнээгээр суралцагч 97-оор, оройгоор суралцагч 66-аар, дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч 1,169-өө тус тус буурсан байна. (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид
(сургалтын хэлбэрээр)

	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид				
	Нийт	өдөр	орой	эчнээ	дүйцсэн
2013-2014	510,203	497,022	588	973	11,620
2014-2015	517,878	506,816	315	680	10,067
2015-2016	546,215	535,055	244	723	10,193
2016-2017	561,693	551,953	177	447	9,116
2017-2018	581,160	572,752	111	350	7,947

Өдрөөр суралцагчдын 94.2 хувь нь төрийн өмчийн сургуульд, 5.8 хувь нь хувийн сургуульд суралцаж байна (Хүснэгт 7). Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад бага ангийн суралцагчдын тоо 6.9, дунд анги 5.3 хувиар тус тус өссөн бол ахлах ангийн суралцагчдын тоо 10.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 7. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид (анги, өмчийн хэлбэрээр)

	Суралцагчдын тоо						
	Бүгд	Төрийн	Хувийн	Бүгд	Бага	Дунд	Ахлах
2013-2014	497,022	468,370	28,652	497,022	239,289	164,633	93,100
2014-2015	505,816	476,676	29,140	505,816	251,204	158,634	95,978
2015-2016	535,055	504,070	30,985	535,055	271,687	147,031	116,337
2016-2017	551,953	520,201	31,752	551,953	288,345	167,364	96,244
2017-2018	572,752	537,740	35,012	572,752	309,355	176,210	87,187

Суралцагчдын 59.3 хувь буюу 339.8 мянга нь нэгдүгээр ээлжинд, 39.4 хувь буюу 225.7 мянга нь хоёрдугаар ээлжинд, 1.3 хувь буюу 7.3 мянга нь гуравдугаар ээлжинд хичээллэж байна. Гуравдугаар ээлжинд хичээллэж байгаа хүүхдийн тоо өмнөх оноос 0.3 пунктээр буурсан байна.

Суралцагчдын хүйсийн харьцаа

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын 49.9 хувийг охид, 50.1 хувийг хөвгүүд бүрдүүлж байгаа нь өмнөх оноос охидын эзлэх хувь 0.3 пунктээр буурсан бол хөвгүүдийн эзлэх хувь эсрэгээрээ өссөн байна. Энэ харьцаа төрийн өмчийн сургуульд 50.0:54.0, хувийн сургуульд 48.7:51.3-тай байна (Хүснэгт 8). Бага ангийн нийт суралцагчдын 48.9 хувь, дунд ангийн 49.6 хувь, ахлах ангийн 54.3 хувийг охид эзэлж байна. Хүйсийн ялгааны индекс 1.0 байна. Өөрөөр хэлбэл, 100 эрэгтэй сурагчид 100 эмэгтэй сурагч ногдож байна гэсэн үг. Ахлах ангид суралцагчдын хүйсийн ялгаа ихэсч байна.

Хүснэгт 8. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид хүйсээр (ангиар)

Үзүүлэлт	бага		дунд		ахлах	
	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
2013-2014	49.0%	51.0%	49.6%	50.4%	53.8%	46.2%
2014-2015	49.0%	51.0%	49.3%	50.7%	54.4%	45.6%
2015-2016	49.0%	51.0%	49.3%	50.7%	54.8%	45.2%
2016-2017	49.0%	51.0%	49.7%	50.3%	54.6%	45.4%
2017-2018	48.9%	51.1%	49.6%	50.4%	54.3%	45.7%

Суралцагчдын насны ангилал

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын 0.07 хувь нь сургуульд элсэх наснаасаа эрт элссэн бол 53.8 хувийг 6-10 настай, 29.2 хувийг 11-14 настай, 16.4 хувийг 15-17 настай, 0.5 хувийг 18 ба түүнээс дээш настай суралцагч бүрдүүлж байна. Сургуулийн эрт элсэлт өмнөх оноос 0.23, 11-14 настай суралцагчид 0.7, 15-17 настай суралцагчид 1.3, 18 ба түүнээс дээш настай суралцагчдын тоо 0.1 пунктээр тус тус буурсан бол 6-10 настай суралцагчдын тоо 2.2 пунктээр өссөн байна.

Хүснэгт 9. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид (насаар)

Он	Суралцагчдын тоо						
	Бүгд	5 хүртэлх нас	6 нас	7-10 нас	11-14 нас	15-17 нас	18 ба түүнээс дээш
2013-2014	497,022	3,616	52,184	172,843	177,462	87,871	3,046
2014-2015	505,816	3,430	58,828	183,452	170,330	87,535	2,241
2015-2016	535,055	2,490	63,449	202,444	163,387	97,996	5,289
2016-2017	551,953	1,672	59,082	225,638	164,260	97,724	3,577
2017-2018	572,752	383	65,359	242,577	167,279	94,179	2,975

Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 7,279 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. Эдгээр хүүхдүүд нь нийт суралцагчдын 1.3 хувийг эзэлж байна. Энэхүү үзүүлэлт нь өмнөх оноос 0.2 пунктээр буурсан байна.

Хүснэгт 10. ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс					
		Харааны	Сонсголын	Хэл ярианы	Оюун ухааны	Бие эрхтэний	Хавсарсан
2013-2014	16,197	7,220	2,060	2,308	1,274	2,017	1,318
2014-2015	11,072	4,104	1,214	1,560	1,185	1,796	1,213
2015-2016	9,143	3,086	1,053	1,387	766	1,374	1,477
2016-2017	8,362	2,632	951	1,286	881	1,252	1,360
2017-2018	7,279	2,102	828	1,136	788	1,091	1,334

Нэгдүгээр ангид шинээр элсэгч

2017-2018 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид суралцагчдын 99.6 хувь (67,974)-ийг шинээр элссэн суралцагч бүрдүүлж байна. Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 9.6 хувиар өссөн бөгөөд суралцагчдын 94.4 хувь нь төрийн өмчийн, 5.6 хувь нь хувийн сургуульд элсжээ. (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Нэгдүгээр ангид шинээр элссэн суралцагчид (өмчийн хэлбэрээр)

Хичээлийн жил	Шинээр элсэгч	Үүнээс		Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан	Шинээр элсэгчдээс сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	Нийт элсэгчдээс шинээр элсэгчдийн эзлэх хувь
		Төрийн өмчийн сургуульд	Хувийн сургуульд			
2013-2014	55,858	52,167	3,691	35,288	63.2	99.8
2014-2015	60,205	56,613	3,592	51,679	85.8	96.5
2015-2016	65,197	61,556	3,641	43,132	66.2	98.7
2016-2017	62,000	58,687	3,313	42,315	68.3	99.6
2017-2018	67,974	64,148	3,826	43,932	64.6	99.6

Элсэгчдийн 92.9 хувийг 6 настай суралцагчид буюу өмнөх оноос 1.6 пунктээр өссөн бол, 0.6 хувийг сургуульд элсэх наснаас эрт буюу 5 настай буюу өмнөх оноос 2.1 пунктээр буурсан байна.

Нийт шинээр элсэгчдийн 6.4 хувийг сургуульд элсэх наснаас хожуу насандаа элссэн суралцагч эзэлж байна. Нийт элсэгчдийн 64.6 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан бөгөөд өмнөх оноос 3.7 пунктээр буурсан бол элсэгчдийн 35.4 хувь нь сургуульд элсэхийн өмнө сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй байна.

Ажиллагчид болон багшлах боловсон хүчин

Ерөнхий боловсролын сургуульд 47,9 мянган ажиллагчид ажиллаж байгаагийн 91.2 хувь нь төрийн өмчийн сургуульд, 8.8 хувь нь хувийн сургуульд ажиллаж байна. Ажиллагчдын тоо өмнөх хичээлийн жилээс 1.7 хувь буюу 823 (төрийн өмчийн сургууль 493-аар, хувийн сургууль 330)–аар нэмэгдсэн.

Хүснэгт 12. Ерөнхий боловсролын сургуулийн ажиллагчид

Хичээлийн жил	Ажиллагчдын тоо	Үүнээс		Төрийн өмч	
		Төрийн өмч	Хувийн өмч	Хот	Хөдөө
2013-2014	45,367	41,797	3,570	11,639	30,158
2014-2015	45,881	41,951	3,930	12,114	29,837

2015-2016	46,791	42,936	3,855	12,645	30,291
2016-2017	47,168	43,261	3,907	13,246	30,015
2017-2018	47,991	43,754	4,237	13,263	30,491

Ерөнхий боловсролын сургуульд 29,4 мянган багш ажиллаж байгаагийн 91.5 хувь нь төрийн өмчийн сургуульд, 8.5 хувь нь хувийн сургуульд ногдож байна. Багшийн тоо өмнөх хичээлийн жилээс 1.2 хувь буюу 353 (төрийн өмчийн сургууль 215-аар, хувийн сургууль 138)–аар нэмэгдсэн. Нийт багш нарын 23,876 буюу 81.6 хувь нь эмэгтэй, 18.4 хувь нь эрэгтэй, 35.0 хувь буюу 11.9 мянга нь бага анги, 65.0 хувь буюу 19.0 мянга нь дунд, ахлах ангийн багш байна.

Хүснэгт 11. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш

	Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш						
	Нийт	бага	дунд	ахлах	Нийт	Төрийн	Хувийн
2013-2014	27,205	8,795	11,184	7,226	27,205	25,027	2,178
2014-2015	27,449	8,901	11,233	7,315	27,449	25,218	2,231
2015-2016	28,490	9,877	11,454	7,159	28,490	26,209	2,281
2016-2017	28,889	9,976	11,708	7,205	28,889	26,527	2,362
2017-2018	29,242	10,238	11,960	7,044	29,242	26,742	2,500

Багш нарын боловсролын түвшин, насны ангилал, ажилласан жил

Нийт багш нарын 0.1 хувийг докторын зэрэгтэй, 13.8 хувийг магистрын зэрэгтэй, 72.4 хувийг бакалавр, 10.7 хувийг дипломын боловсролтой багш эзэлж байна. (Хүснэгт 12). Өмнөх жилээс магистрийн зэрэгтэй багш хэвээр, дипломын боловсролтой багшийн тоо 1.5, бакалаврын зэрэгтэй багш 0.1 пунктээр тус тус буурсан байна.

Хүснэгт 12. Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа үндсэн багшийн боловсролын түвшин

Хичээлийн жил	Боловсролын түвшин ¹	Үүнээс:				
		Доктор	Магистр	Бакалавр	Диплом	Бусад
2013-2014	99.4	15	2,871	19,414	4,732	173
2014-2015	99.8	23	3,670	19,441	4,263	52
2015-2016	98.9	22	4,085	20,142	3,916	325
2016-2017	98.6	23	3,983	20,949	3,530	404
2017-2018	97.0	23	4,034	21,185	3,131	869

Багш нарын 28.5 хувь нь 30 хүртэл насны, 36.0 хувь нь 30-39 насны, 23.3 хувь нь 40-49 насны, 11.5 хувь нь 50-59 насны, 0.7 хувь 60 ба түүнээс дээш насны багш нар байна. 30 хүртэл насны багшийн тоо 0.5 пунктээр буурсан бол 30-39 насны багшийн тоо хэвээр, 40-49 насны багшийн тоо 0.7 пунктээр өссөн байна.

Хүснэгт 13. Багш нарын нас (насны ангилалаар)

	30 хүртэл	30-39	40-49	50-59	60 ба түүнээс дээш
2013-2014	8,370	9,686	5,519	3,447	183
2014-2015	8,222	10,011	5,688	3,369	159

¹ Боловсролын түвшин -Дипломоос дээш боловсролтой багшийн хувь

2015-2016	8,469	10,277	6,056	3,515	173
2016-2017	8,378	10,406	6,520	3,389	196
2017-2018	8,331	10,526	6,807	3,365	213

Багш нарын ажилласан жил буюу ажлын туршлагыг авч үзэхэд нийт багш нарын 5.9 хувь нь анхны жилдээ, 31.8 хувь нь 1-5 жил, 20.1 хувь нь 6-10 жил, 15.6 хувь нь 11-15 жил, 9.9 хувь нь 16-20, 4.9 хувь нь 21-25, 11.7 хувь нь 25-аас дээш жил ажиллаж байна.

Өмнөх жилээс анхны жилдээ ажиллаж байгаа багш 0.1, 11-15 жил ажиллаж буй багш 0.5, 16-20 жил ажилласан багш 0.7 пунктээр тус тус өссөн бол, 1-5 жил ажиллаж буй багш 0.8, 6-10 жил ажиллаж буй багш 0.3, 25-аас дээш ажиллаж буй багш 0.3 пунктээр тус тус буурсан байна.

Хүснэгт 14. Багш нарын ажлын туршлага (ажилласан жилээр)

	Ажилласан жил						
	Анхны жилдээ	1-5 жил	6-10 жил	11-15 жил	16-20 жил	21-25 жил	25-аас дээш жил
2013-2014	934	6,585	6,554	4,115	2,524	2,312	4,181
2014-2015	611	8,196	6,974	4,158	2,465	1,979	3,066
2015-2016	2,110	8,869	5,740	4,785	2,321	1,396	3,269
2016-2017	1,675	9,405	5,892	4,348	2,669	1,420	3,480
2017-2018	1,732	9,287	5,866	4,576	2,900	1,446	3,435

Багш нарын 40.4 хувь нь мэргэшлийн зэрэгтэй тэдгээрийн 0.9 хувийг зөвлөх, 29.5 хувийг тэргүүлэх, 69.6 хувийг заах аргач зэрэгтэй багш бүрдүүлж байна. Өмнөх жилээс зэрэгтэй багшийн эзлэх хувь 5.9 пунктээр буурсан бол, зөвлөх зэрэгтэй багшийн эзлэх хувь 0.1, тэргүүлэх зэрэгтэй багшийн хувь 0.4 пунктээр тус тус өсч, заах аргач зэрэгтэй багшийн хувь 0.5 пунктээр буурсан байна.